

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5-13
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХАН ХЭНТИЙН УЛСЫН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.ХАШМАРГАД ТАНАА

2021.02.25 № 07/485
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам 89.6 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагыг хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч, материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	173,893,629.76	135,807,743.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	2,861,820.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	2,861,820.00
35	БАРАА МАТЕРИАЛ	173,893,629.76	132,945,923.26
354	Хангамжийн материал	173,893,629.76	132,945,923.26
35410	Бичиг хэргийн материал	00.00	4,633,970.00
35420	Аж ахуйн материал	37,284,207.00	52,974,977.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,945,000.00	15,360,100.00
35440	Түлш, шатах тослох материал	1,905,000.00	2,751,050.00
35450	Барилгын засварын материал	848,100.00	14,432,182.00
35470	Бусад хангамжийн материал	126,911,322.76	42,793,644.26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	834,105,956.42	1,020,916,139.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	834,105,956.42	1,020,916,139.66
392	Биет хөрөнгө	820,894,623.18	1,008,244,806.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	297,505,017.63	464,346,498.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,724,948.08)	(55,062,335.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	585,219,020.20	540,428,368.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(256,080,332.70)	(188,750,011.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,372,737.04	190,199,957.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,646,612.08)	(96,246,093.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	163,456,832.09	216,261,113.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,753,267.35)	(86,807,395.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,304,705.00	32,884,705.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,758,528.57)	(9,009,999.93)
393	Биет бус хөрөнгө	13,211,333.24	12,671,333.20
39301	Програм хангамж	4,000,000.00	3,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(926,666.76)	(1,366,666.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,138,000.00	10,138,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,007,999,586.18	1,156,723,882.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,007,750.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,007,750.20
413	Өглөг	00.00	3,007,750.20
41310	ХХОАТ-ын өглөг		154,750.20
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,853,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,007,999,586.18	1,153,716,132.72
51	Засгийн газрын хувь оролцоо	1,007,999,586.18	1,153,716,132.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	277,853,666.84	277,853,666.84
51101	Өмч: - төрийн	277,853,666.84	277,853,666.84
512	Хуримтлагдсан үр дүн	694,569,386.50	840,285,933.04
51210	Өмнөх үеийн үр дүн	694,569,386.50	694,569,386.50
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	145,716,546.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,576,532.84	35,576,532.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,007,999,586.18	1,156,723,882.92

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,013,718,205.11	1,432,605,650.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	257,733,193.59	286,780,167.45
120	Нийтлэг татварын бус орлого	257,733,193.59	286,780,167.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	257,733,193.59	34,020,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,484,488.28	34,020,500.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	241,348,705.31	00.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,900,000.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө		252,759,667.45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	755,985,011.52	1,145,825,483.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	616,158,700.00	847,748,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	616,158,700.00	847,748,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139,826,311.52	298,077,383.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,867,115.52	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	47,500,000.00	88,231,483.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	70,459,196.00	209,845,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	887,145,131.17	1,286,889,103.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	887,145,131.17	1,286,889,103.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	881,806,218.87	1,120,820,060.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	512,879,041.87	571,529,705.00
210101	Үндсэн цалин	284,069,448.47	353,405,896.92
210102	Нэмэгдэл	140,028,693.40	134,631,201.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,448,700.00	25,101,562.25
210105	Гэрээт ажлын хөлс	69,332,200.00	58,391,044.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,060,614.32	68,796,470.68
210201	Тэтгэврийн даатгал	44,076,914.33	47,954,882.68
210202	Тэтгэмжийн даатгал	4,996,000.00	4,933,271.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,996,699.99	4,136,108.00
210204	Ажилгүйдлийн даатгал	999,200.00	1,070,201.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,991,800.00	10,702,008.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,020,445.72	23,126,642.00
210301	Гэрэл, цахилгаан	208,445.72	414,242.00
210302	Түлш, халаалт	00.00	5,258,400.00
210303	Цэвэр, бохир ус	32,000.00	4,000.00

210304	Байрны түрээс	9,780,000.00	17,450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,173,101.75	80,266,979.15
210401	Бичиг хэрэг	8,359,620.00	4,120,933.00
210402	Тээвэр, шатахуун	28,685,123.80	38,522,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,987,267.95	3,782,199.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	141,090.00	14,869,391.34
210408	Бараа материал акталсны зардал	00.00	18,971,505.00
2105	Нормативт зардал	00.00	50,723,802.16
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	50,723,802.16
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,483,550.00	11,956,780.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	336,600.00	27,000.00
210604	Урсгал засвар	16,146,950.00	11,929,780.00
2107	Томилолт, зочны зардал	17,752,229.00	4,093,000.00
210701	Гадаад албан томилолт	7,828,829.00	00.00
210702	Дотоод албан томилолт	9,923,400.00	4,093,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,481,897.86	69,886,307.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,043,519.86	67,651,295.25
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	812,000.00	812,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	977,700.00	975,112.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	163,678.00	270,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	177,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,955,338.35	240,440,374.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,689,700.00	85,803,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,788,880.00	950,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,476,758.35	153,686,504.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,338,912.30	166,069,043.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,990,671.00	67,064,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,990,671.00	67,064,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,348,241.30	99,004,743.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,348,241.30	98,929,050.46
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг/ нэмэлт/		75,693.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	126,573,073.94	145,716,546.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	126,573,073.94	145,716,546.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	765,269,499.80	1,180,095,983.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,284,488.28	34,270,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,284,488.28	34,270,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,284,488.28	34,270,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,284,488.28	34,270,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	755,985,011.52	1,145,825,483.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	616,158,700.00	847,748,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	616,158,700.00	847,748,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139,826,311.52	298,077,383.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,867,115.52	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,500,000.00	88,231,483.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,459,196.00	209,845,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	765,269,499.80	1,180,095,983.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	765,269,499.80	1,180,095,983.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	759,930,587.50	1,011,165,119.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	512,483,579.85	549,586,018.38
210101	Үндсэн цалин	283,673,986.45	335,462,210.30
210102	Нэмэгдэл	140,028,693.40	130,631,201.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,448,700.00	25,101,562.25
210105	Гэрээт ажлын хөлс	69,332,200.00	58,391,044.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,060,611.32	68,796,470.68
210201	Тэтгэврийн даатгал	44,076,911.32	47,954,882.68
210202	Тэтгэмжийн даатгал	4,996,000.00	4,933,271.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,996,700.00	4,136,108.00
210204	Ажилгүйдлийн даатгал	999,200.00	1,070,201.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,991,800.00	10,702,008.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,645,445.72	22,628,642.00
210301	Гэрэл, цахилгаан	208,445.72	774,242.00
210302	Түлш, халаалт	00.00	4,385,700.00
210303	Цэвэр, бохир ус	32,000.00	18,700.00
210304	Байрны түрээс	14,405,000.00	17,450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,762,561.75	45,791,599.81
210401	Бичиг хэрэг	830,630.00	1,316,100.00
210402	Тээвэр, шатахуун	25,274,473.80	39,171,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,387,267.95	3,782,199.81

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	270,190.00	1,522,300.00
2105	Нормативт зардал	336,600.00	8,976,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	336,600.00	8,976,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,636,700.00	120,574,020.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	369,600.00	92,683,420.00
210604	Урсгал засвар	15,267,100.00	27,890,600.00
2107	Томилолт, зочны зардал	17,752,229.00	4,093,000.00
210701	Гадаад албан томилолт	7,828,829.00	00.00
210702	Дотоод албан томилолт	9,923,400.00	4,093,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,435,179.86	126,436,098.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,996,801.86	124,128,586.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	812,000.00	812,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	977,700.00	975,112.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	163,678.00	270,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,817,680.00	64,282,670.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,155,300.00	62,953,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,662,380.00	1,328,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,338,912.30	168,930,863.46
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,348,241.30	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,348,241.30	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,990,671.00	67,064,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,990,671.00	67,064,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	101,866,563.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	98,929,050.46
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг/ нэмэлт/		2,937,513.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	567,996,312.56	881,426,512.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	567,996,312.56	881,426,512.24
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	126,573,073.94	126,573,073.94
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	694,569,386.50	1,007,999,586.18
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	694,569,386.50	1,007,999,586.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	694,569,386.50	1,007,999,586.18
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	145,716,546.54	145,716,546.54
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,853,666.84	35,576,532.84	840,285,933.04	1,153,716,132.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Эхний үлдэгдэл		0.00	0.00	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	856,748,100.00	783,089,549.54	73,658,550.46	91.4
УРСГАЛ ЗАРДАЛ	856,748,100.00	783,089,549.54	73,658,550.46	91.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,748,100.00	783,089,549.54	73,658,550.46	91.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	601,101,400.00	549,586,018.38	51,515,381.62	91.4
Үндсэн цалин	338,481,400.00	335,462,210.30	3,019,189.70	99.1
Нэмэгдэл	163,821,300.00	130,631,201.02	33,190,098.98	79.7
Унаа хоолны хөнгөлөлт	28,162,400.00	25,101,562.25	3,060,837.75	89.1
Гэрээт ажлын хөлс	70,636,300.00	58,391,044.81	12,245,255.19	82.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,148,800.00	68,796,470.68	12,352,329.32	84.8
Тэтгэврийн даатгал	57,104,600.00	47,954,882.68	9,149,717.32	84.0
Тэтгэмжийн даатгал	6,011,100.00	4,933,271.00	1,077,829.00	82.1
ҮОМШӨ-ний даатгал	4,808,900.00	4,136,108.00	672,792.00	86.0
Ажилгүйдлийн даатгал	1,202,200.00	1,070,201.00	131,999.00	89.0
Эрүүл мэндийн даатгал	12,022,000.00	10,702,008.00	1,319,992.00	89.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,215,500.00	22,628,642.00	586,858.00	97.5
Гэрэл, цахилгаан	1,000,000.00	774,242.00	225,758.00	77.4
Түлш, халаалт	4,385,700.00	4,385,700.00	0.00	100.0
Цэвэр, бохир ус	20,000.00	18,700.00	1,300.00	93.5
Байрны түрээс	17,809,800.00	17,450,000.00	359,800.00	98.0
Хангамж, бараа материалын зардал	45,792,600.00	45,791,599.81	1,000.19	100.0
Бичиг хэрэг	1,316,200.00	1,316,100.00	100.00	100.0
Тээвэр, шатахуун	39,171,900.00	39,171,000.00	900.00	100.0

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,782,200.00	3,782,199.81	0.19	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,522,300.00	1,522,300.00	0.00	100.0
Нормативт зардал	336,600.00	336,600.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	336,600.00	336,600.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	750,300.00	750,300.00	0.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	750,300.00	750,300.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	4,093,000.00	4,093,000.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	4,093,000.00	4,093,000.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,981,000.00	89,778,018.67	9,202,981.33	90.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,670,900.00	87,470,506.67	9,200,393.33	90.5
Даатгалын үйлчилгээ	812,000.00	812,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	977,700.00	975,112.00	2,588.00	99.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	270,400.00	270,400.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,328,900.00	1,328,900.00	0.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,328,900.00	1,328,900.00	0.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	855,748,100.00	783,089,549.54	72,658,550.46	91.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	847,748,100.00	748,819,049.54	98,929,050.46	88.3
Улсын төсвөөс санхүүжих	847,748,100.00	748,819,049.54	98,929,050.46	88.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,000,000.00	34,270,500.00	(26,270,500.00)	428.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	34,270,500.00	(26,270,500.00)	428.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	56	51	5	91.0
Удирдах ажилтан	1	1	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	38	33	5	86.8
Үйлчлэх ажилтан	9	9	0	100.0
Гэрээт ажилтан	8	8	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	295,139,870.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	295,139,870.00
Бараа, үйлчилгээний зардал	-	228,075,570.00
Нормативт зардал	-	8,640,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	8,640,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	119,823,720.00
Багаж, техник, хэрэгсэл	-	91,933,120.00
Урсгал засвар	-	27,890,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	36,658,080.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	36,658,080.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	62,953,770.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	62,953,770.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	70,001,813.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,937,513.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,937,513.00
Бусад урсгал шилжүүлэг	-	67,064,300.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	67,064,300.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	298,077,383.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	298,077,383.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	88,231,483.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	209,845,900.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус хамгаалалтын захиргааны Дарга Б.Хашмаргад танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн цалин болон түүнтэй адилтгах орлоготой холбоотой татварын суутгалын талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 11-нээс 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Нью Эстимэйтор аудит ХХК-ийн Захирал Т.Бүжидмаа, аудитор Ж.Үхэртар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь Хан Хэнтийн дархан цаазат газар, Өндөрхаан уулын байгалийн цогцолборт газар, Хангал нуурын байгалийн дурсгалт газар, Бэндэръяа уулын байгалийн дурсгалт газрын хилийн зааг дотор багтаж буй газар нутгийн биологийн төрөл, зүйл томоохон гол мөрөн, байгаль түүх, соёлын дурсгалын байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, шинжлэн судалж зүй зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх бодлогын хэрэгжилтийг хангуулах
- Хамгаалалтын менежментийг хэрэгжүүлж, судалгаа, шинжилгээний ажил хийх
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялалын дэд бүтцийг бий болгох, хамтын ажиллагааг сайжруулах
- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментэд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх
- Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ
- Иргэнд чиглэсэн үйлчилгээ
- Мэргэжилтэй ажилтанд зориулсан үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тус төвийн тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгээгүй байна.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 435,808.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,716.2 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 145,862.5 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	173,893.6	132,945.9	(40,947.7)
Авлага	-	2,861.8	2,861.2
Үндсэн хөрөнгө	834,105.0	1,020,916.2	186,811.2
Нийт хөрөнгө	1,007,999.6	1,156,723.9	148,724.3
Өр төлбөр		3,007.8	3,007.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,007,999.6	1,153,716.1	145,716.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,007,999.6	1,156,723.9	148,724.3

Авлага дансны үлдэгдэл 2,861.2 мянган төгрөг болсон нь Байгаль хамгаалах уур амьсгалын сангаас оны сүүлд орж ирсэн 2,861.2 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулалгүй төсөвт төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 132,945.9 мянган төгрөг болж 40,947.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй нормын хувцас тавьж олгосноос, мөн ашиглалтгүй болсон 18,971.5 мянган төгрөгийн аж ахуйн материалыг байгууллагын даргын А/47-дугаар тушаалаар акталснаас тус тус шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,020,916.2 мянган төгрөг болж 186,811.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө, гадны байгууллагын тусламж болон үйл ажиллагааны давсан орлогоор худалдан авсан хөрөнгөөс шалтгаалжээ. Энэ нь Монгол дахь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөрөнгө оруулалтаар 70,437.1 мянган төгрөг, үйл ажиллагааны давсан орлогоос 17,300.0 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 687 дугаар тогтоолоор үнийг шинэчлэн тогтоосон 2,964.7 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 331 дугаар тогтоолоор 166,841.5 мянган төгрөгийн барилга, БОАЖЯ-ны сайдын А/380 дугаар тушаалаар 39,190.0 мянган төгрөгийн мотоцикл, БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн даргын А/257 дугаар тушаалаар 43,763.4 мянган төгрөгийн тавилга хүлээн авснаар үнэ төлбөргүй хүлээж авсан 249,794.9 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 360 болон 393 дугаар тогтоолоор акталсан 124,334.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,007.8 мянган төгрөг болж 3,007.8 мянган төгрөгөөр өссөн нь 154.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өрийг барагдуулаагүй болон Эбээ ХХК-д гэрээний төлбөрийн үлдэгдэл болох 2,853.0 мянган төгрөгийг төлөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,153,716.5 мянган төгрөг болж 145,716.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 418,887.5 мянган төгрөгөөр буюу 41 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн үйл ажиллагааны орлого болон үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого байна. Энэ нь гоожингийн орлогыг төлөвлөөгүй болон тайлант жил байгалийн нөөц болох самар их ургаж самрын хураамжийн орлого эрс нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 302,087.5 мянган төгрөгөөр буюу 34 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс болон бараа материал акталсны зардал болон бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 67,064.3 мянган төгрөг байгаа нь үйл ажиллагааны давсан орлогыг захиран зарцуулах хүрээнд ажилчиддаа урамшуулал олгож, бүрэн эмнэлэгийн үзлэгт хамруулсантай холбоотой байна. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 14,869.4 мянга байгаа нь замын тэмдэглэгээ болон элэгдсэн аяны хөнжил бүртгэснээс, бараа материал акталсан зардалд цаашид ашиглах боломжгүй 18,971.5 мянган төгрөгийн аж ахуйн материал устгаснаас, бараа үйлчилгээний бусад зардал дансанд 85,803.9 төгрөг хуримтлуулан бүртгэсэн нь БОАЖЯ-руу давсан орлогоос 62,953.8 мянга шилжүүлсэн болон нэвтрэх тасалбарын зардал болох 22,850.1 мянган төгрөгийн зардлыг хуримтлуулан бүртгэснээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 856,748.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 856,748.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,000.0 мянган төгрөгөөр бууруулж 855,748.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 855,748.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 847,748.1 мянган төгрөгийг улсын төсвөөс 8,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 847,748.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 34,270.5 мянган төгрөг нийт 882,028.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 783,089.5 мянган төгрөгийг зарцуулж 98,929.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 783,089.5 мянган төгрөг буюу 91 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 51,515.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 9,203.0 мянган төгрөг, үүнтэй холбоотойгоор ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 12,352.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 1,000.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 586.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 12 ны өдрийн А/79 тоот тушаалаар 56

хүнээр бүтэц орон тоо батлагдсан боловч хөдөө орон нутагт ажиллах экологич, байгаль хамгаалагчийн дээд боловсролтой, төрийн албаны шалгалтанд тэнцсэн гэх шаардлагыг хангах мэргэжлийн хүн олдохгүй шалтгаанаар 8 байгаль хамгаалагчийн цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хэмнэгдсэн байна. 2020 оны төсөвт шинээр гэрээт ажиллагсдын зардал батлагдан тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийн үйл ажиллагааг тогтворжуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор гэрээгээр ажил гүйцэтгүүлэх үйлчилгээний ажилтан 9 ажилтан шинээр авч ажиллуулж байна. Тухайн ажлын байрны онцлогоос шалтгаалан улирлын чанартай ажиллуулах, ковид-19 цар тахлын хөл хорионоос шалтгаалан цөөн сар ажилласан гэх зэрэг шалтгаанаар тухайн зардал 8,199.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулагджээ. Мөн хамгаалалтын захиргааны хөдөө орон нутагт байрладаг мэдээлэл сургалт сурталчилгааны төвүүдийн гэрэл цахилгааны зардал хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монгол дахь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн /GIZ/ төслөөс 70,491.5 мянган төгрөг, Байгаль хамгаалах сангаас 9,539.4, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн хөтөлбөрөөс 8,200.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 209,845.9 мянга, нийт 298,077.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс БОАЖЯ-руу 62,953.8 мянган төгрөг шилжүүлсэн, тусгай тоноглолтой машин худалдан авахад 35,650.0 мянга, хяналтын камер тоног төхөөрөмж авахад 33,487.0 мянга, хилийн багананд тэмдэг тэмдэглэгээ хийлгэхэд 8,200.0 мянга, мод үржүүлгийн талбай байшин засахад 6,657.0 мянга, ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад 26,457.3 мянга, ажилтнуудын урамшуулалд 40,606.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжинд 21,801.1 мянга, ажилтнуудын өвлийн гутал нормын хувцас авахад 8,640.0 мянга, техник тоног төхөөрөмж эд хогшил худалдан авахад 22,796.1 мянга, байгаль хамгааллын хяналтын байр, мэдээллийн төвүүдийн засвар үйлчилгээнд 27,890.6 нийт 295,139.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,937.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого байхгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 124 мэдээлэл, хугацаа болоогүй 4 мэдээлэл, хугацаа хоцроосон 23 мэдээлэл байна

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт болон албан шаардлага байхгүй байна. Аудитаар өгсөн 1,480.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	1,480.0	1	1,480.0	-	-	-
Нийт дүн	1	1,480.0	1	1,480.0	-	-	-

/мянган.төг/

Хэрэгжүүлээгүй зөвлөмж байхгүй. Акт, албан шаардлага тавигдаагүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил болон 2,477.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс шилэн дансны зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,477.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илэрч уг зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ бүртгэхээс 5,000.0 мянган төгрөгийн дүнтэй 1 орлогын гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй,
- Худалдан авалттай холбогдох гэрээ, гэрээ дүгнэсэн акт байршуулаагүй
- Хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 12 шийдвэр, түүний хуулбарыг бүрэн байршуулаагүй, 1 шийдвэрийн хуулбар буруу байршуулсан байна..

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны шилэн дансанд байршуулсан мэдээллүүдээс 5.0 сая төгрөгөөс дээш 1 орлогын гүйлгээ оруулаагүй худалдан авалттай холбогдох гэрээ, гэрээ дүгнэсэн акт оруулаагүй. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой мэдээний зарим шийдвэр, шийдвэрийн хуулбарыг бүрэн байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитаар цалин болон түүнтэй адилтгах орлоготой холбоотой илэрсэн 2,477.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь орчны бүсийн сумдын засаг дарга нартай хамтран ажиллах төлөвлөгөө батлан гэрээ байгуулж ажилладаг. Уг гэрээнд Тусгай хамгаалалттай газар нутгаас хуулийн дагуу ойн болон байгалийн дагалдах баялаг, нөөц ашигласны төлбөрийн 60 хувьтай тэнцэх орлогыг тухайн сумын орон нутгийн ойн нөөцийн төлбөрийн дансанд төвлөрүүлдэг. Энэ онд төвлөрүүлсэн орлогод нарийн тооцоо хийж шилжүүлэг хийгээгүй нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хөдөлмөрийн тухай хууль болон тус байгууллагын дотоод журмын 8.8.4-д заасны дагуу захирлын тушаалаар ажилтан болон түүний гэр бүлд олгосон 12 удаагийн нийт 12,173.3 мянган төгрөгийн тэтгэмжээс 1,399.9 мянган төгрөгийн НДШ, 1,077.3 мянган төгрөгийн ХХОАТ суутгалгүйгээр олгосон байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаагаас гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дугаарт зааснаар ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод хамаарна. Энэ хуулийн 14.1 дүгээрт Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Шимтгэл суутгалыг үнэн зөв тооцоогүйгээс төсөвт бүрэн төвлөрүүлэхгүй байх мөн санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод зохих шимтгэл, суутгалыг тооцож олгох.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйл Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулахдаа уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна гэсэн заалтыг хэрэгжүүлэх, Нийгмийн даатгалыг шимтгэлийн тухай хуулийн 17.1 дүгээрт зааснаар “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэж заасныг хэрэгжүүлэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.02.20			САГ-2021/351/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажилчид болон түүнийгэр бүлд олгосон 12,173.3 мянган төгрөгийн тэтгэмжээс 1,399.9 мянган төгрөгийн НДШ, 1,077.3 мянган төгрөгийн ХХОАТ суутгаж төсөвт төвлөрүүлээгүй	2,477.2	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	П.Оюунтунгалаг
2	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй	5,000.0	Албан шаардлага хүргүүлэх	Нягтлан бодогч	П.Оюунтунгалаг
	ДҮН	7,477.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 59/АД/170078

Улаанбаатар хот

С.ЯТ-2021/351/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээтэй холбоотой гэрээ, гэрээ дүгнэсэн актыг огт байршуулаагүй, 5,000.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогын 1 гүйлгээг орхигдуулсан, мөн хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 12 мэдээний шийдвэрийн хуулбарыг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны дарга Б.Хашмаргад, нягтлан бодогч П.Оюунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ЦЭРЭНХҮҮ
Ж.ҮХЭРТАР